



БАТЛАВ.



**ШИНЭ ТӨРЛИЙН КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ҮЕД  
ШААРДЛАГАТАЙ ЭМ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ЖИЖИГ ХЭРЭГСЭЛ НИЙЛҮҮЛЭХ  
ГЭРЭЭ**

Дугаар № 468

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн яам (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас ЧИНБАЯН ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 12 дүгээр сарын 09-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед шаардлагатай “БУДЕСОНИД” худалдан авах гэрээг (цаашид “бараа” гэх) 270.000.000,00 (хоёр зуун далан сая) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Хүснэгт 1. Нийлүүлэх бараа

| Д/д | Барааны нэр, төрөл | Багцын дугаар | Үйлдвэрлэгч, Улс | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгж үнэ /НӨАТ орсон/ | Нийт үнэ       |
|-----|--------------------|---------------|------------------|-------------|------------|-----------------------|----------------|
| 1   | Будесонид          | 22            | Энэтхэг          | Ширхэг      | 90.000     | 3000                  | 270.000.000,00 |
|     |                    |               |                  |             |            |                       |                |
|     | Нийт дүн           |               |                  |             |            |                       | 270.000.000,0  |

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг 270.000.000,00 (хоёр зуун далан сая) төгрөгийг Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь 1 нэр төрлийн барааг 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>1</sup>;  
Тендер ба үнийн хуваарь;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Хүснэгт 2. Санхүүжилтийн хуваарь

| Д/Д      | Барааны нэр, төрөл | Багцын дугаар | Урьдчилгаа /төгрөг/ 50% | Гүйцэтгэл /төгрөг/ 50% |
|----------|--------------------|---------------|-------------------------|------------------------|
| 1        | Будесонид          | № 22          | 135.000.000,00          | 135.000.000,00         |
| Нийт дүн |                    |               |                         |                        |

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Нэр томъёо Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- (а) “Гэрээ” гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд тохиролцсон бараа нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.
- (б) “Гэрээний үнэ” гэж гэрээний дагуу гэрээний үүргээ бүрэн биелүүлж хангалттай гүйцэтгэсний дагуу нийлүүлэгчид төлөх үнийг хэлнэ.

<sup>1</sup>Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

26. Маргааныг шийдвэрлэх (ГЕН-ийн Зүйл 26)

ГЕН 26 ГЕН-ийн 26-д хамаарах тусгай нөхцөл байхгүй

27. Гэрээнд ашиглах хэл (ГЕН-ийн Зүйл 27)

ГЕН 27.1 Монгол хэл

28. Гэрээнд мөрдөх хууль (ГЕН-ийн Зүйл 28)

ГЕН 28.1 Гэрээнд Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөнө

29. Мэдэгдэл (ГЕН-ийн Зүйл 29)

ГЕН 29.1 Эрүүл мэндийн яам, Засгийн газрын 8 дугаар байр, Улаанбаатар-48, Олимпийн гудамж-2

30. Татвар, хураамж (ГЕН-ийн Зүйл 30)

ГЕН 30 Монгол Улсын нутаг дэвсгэрийн гаднаас болон дотоодоос нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгалын бодисыг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэн ХӨСҮТ-д болон эцсийн цэгт захиалагчид хүргэх хүртэл оногдуулсан бүх татвар хураамж, тээвэр, даатгал болон бусад зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Шийдвэрлэл, технологийн газрын  
.....Н.Гэрэлт-Од

Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын газрын

.....Д.Нарантуяа

Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн  
хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга  
.....Г.Цэцэнсанаа

Эрүүл мэндийн яамны Эдийн засаг,  
санхүүгийн хэлтсийн дарга  
.....Т.Хонгорзул

Эрүүл мэндийн яамны хуулийн хэлтсийн  
гэжиглээн  
.....Д.Мөнхцэцэг

Эрүүл мэндийн яамны нярав  
.....П.Энхболор

10 Улаанбаатар хот Сүхбаатар  
дугаар Олимпийн гудамж 2, Засгийн газрын  
байр

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЧИНБАЯН ХХК-ны

Захирал .....Б.Цацрал

Хаяг: УБ.ЧД.3-р хороо 48-201  
Утас: 99171617

Харилцах банк: ХАС

Дансны дугаар: 5002801212